



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар А/290

Улаанбаатар хот

ОЙН ДАГАЛТ БАЯЛГИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ"-г хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газар /Б.Оюунсанаа/, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар /Д.Батмөнх/ нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/125 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-
ний өдрийн А/290 дугаар тушаалын хавсралт

Ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

№	Ойн дагалт баялгийн нэрс	Ашиглалтын зориулалтаар, кг/ төг		
		Судалгаа, шинжилгээний	Ахуйн	Үйлдвэрлэлийн
1.	Хуш модны самар <i>Pinus sibirica Du Tour</i>	1000	1000	1400
Жимс				
2.	Монос <i>Padus asiatica ком</i>	600	600	1200
3.	Долоогоно <i>Crataegus sanguinea Pall</i>	5200	1000	6900
4.	Өндөр улаагана /хад/ <i>Ribes altissimum Turcz.</i>	800	600	1000
5.	Улаан улаагана /улаалзгана/ <i>Ribes rubrum L</i>	800	600	1000
6.	Яшилдуу чацаргана <i>Hippophae rhamnoides L.</i>	600	400	800
7.	Нэрс /хөх нэрс/ <i>Vaccinium uliginosum L</i>	800	600	900
8.	Анис, алирс <i>Vaccinium vitas idaea L</i>	800	600	1100
9.	Үхрийн нүд <i>Ribes nigrum</i>	800	600	1200
10.	Өргөст нохойн хошуу <i>Rosa acicularis Lindl.</i>	600	500	900
11.	Гүзээлзгэнэ <i>Fragaria orientalislosinsk</i>	1000	600	2000
12.	Далан хальс <i>Lonicera altaica</i>	500	500	900
Мөөг				

13.	Юүлүүр ташуумаг <i>Clitocybe gibba Kumm</i>	600	600	800
14.	Ягаан сархиаг <i>Lactarius torminosus S.F.Gray.</i>	600	600	800
15.	Шар-ногоон ур мөөг <i>Laetiporus sulphureus Bond. Et Sing</i>	600	600	800
16.	Хэврэг чидмэг <i>Russula emetica S.F.Gray</i>	600	600	800
17.	Тосондой <i>Suillus flat</i>	600	600	800
18.	Эгэл далбига <i>Agaricus campestris Fr.</i>	600	300	600
Бусад				
19.	Хөвд <i>Sphagnum</i>	600	300	600
20.	Хусны шүүс, л	1000	1000	2000
21.	Нарсны шилмүүс	800	800	1600
22.	Давирхай	7700	3900	7700
23.	Хусны навч	1000	1000	2000

Тайлбар: Энэ жагсаалтаар төлбөрийн хэмжээ нь тогтоогдоогүй ойн дагалт баялгийг ашиглах тохиолдолд овог, төрөл, зүйлийн хамаарлаар нь төлбөрийн хэмжээг адилтган тогтоож болно.